

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/ жилийнэ эцэс байдлаар/

2023.12.01

Багахангай дүүрэг

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
1	Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөж, батлуулах, хэрэгжилтийг хангах 1.2 АТГ-аас бэлтгэсэн тв, шторк, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зураг хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх	Дүүргийн Засаг даргын 2023 оны А/59 дүгээр захирамжаар дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 13 арга хэмжээтэйгээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 95.3%-тай байна. "Шүгэл ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аянд нэгдэн Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн "Үгүй гэж хэлээд өөрчилье", "Нэгдэх үү юуны төлөө", "Авлигатай тэмцэх таны оролцоо чухал", "Авлигын эсрэг ҮГҮЙ гэж хэлээд өөрчилье", "Бусдын боломжийг булаахгүй байх учраас ҮГҮЙ гэж хэлээд өөрчилье" видео контент, "Авлигын эсрэг нэгдье" 6 төрлийн постерийг дүүргийн badakhangaib.gov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудсуудаар сурталчлан ажиллаа. "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар шүгэл үлээхийг уриалан ажиллаж хороодтой хамтран "Авлига гэдэг нь зөвхөн бэлэн мөнгө солилцох үйлдэл биш", "АТГ-аас 2022 онд мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн болон, 2022 онд улсын төсөвт учирсан нийт хохирол" шторк 150 ширхэг, "НЭГДЬЕ үгүй гэж хэлээд өөрчилье" стейкэр 200 ширхгийг дүүргийн төрийн болон төрийн бус 43 аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээний 22 байгууллага, амралт чөлөөт цагийн 3 талбай, худаг-3, гэрлийн 60 шон, орон сууцны 20 байрны 61 орцны зарын самбарт байршуулан ажиллаа.	100

		1.3 Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх аянд нэгдэн "Авлигын эсрэг нэгдье" 6 төрлийн постер, шүгэл үлээхийг уриалсан 150ш шторк, "НЭГДЬЕ үгүй гэж хэлээд өөрчилье" 200ш стейкэрийг дүүргийн badakhangaib.dov.mn веб сайт, байгууллагын фейсбүүк хуудас, гудамж талбайд байршуулан сурталчлан ажиллав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Мэдье, Нэгдье" аянд нэгдэн удирдамжийн дагуу авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр 9 зорилт арга хэмжээг зохион байгуулан биелэлтийг ТЗУХ-ийн даргын 4/824 дугаар албан бичгээр НЗДТГ-т хүргэв.	100
		1.4 Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах мэдээллийн самбар байршуулах	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны самбарт Авлигын үйл ажиллагааг мэдээлэх "АВЛИГЫН МЭДЭЭЛЭЛ" цонх байршуулан сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Мөн дүүргийн веб сайтын Ил тод үндсэн зэсэд Авлигын эсрэг үйл ажиллагааны дэд зэс нээлгэн Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, Шүүр ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийн захирамж, хэрэгжилтийн тайлан, "Шил" ажиллагааны хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайланг байршуулаад байна.	100
2	Авлигын эсрэг зохион байгуулах, албан АТГ-ын сургалтад хамруулах	2.1 АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулах	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Авлигын эсрэг" сургалтад Төрийн албанд шинээр томилогдсон 5 албан хаагч, "Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах тухай" цахим сургалтад шинээр томилогдсон эрх бүхий 2 албан тушаалтан, "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам", "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө" түүний хэрэгжилт, үд дүнг хэлэлцэх	100

		сургалтад 1 албан хаагчийг хамрууллаа. Дүүргийн хэмжээнд ЭБАТ хариуцан ажилладаг эрх бүхий албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгөн ажиллаж байна. Тайлангийн хугацаанд бүртгэлийн системд ЭБАТ-ын эрх нь цуцлагдсан байсан 1 эрх бүхий албан тушаалтын эрхийг сэргээн өгч, шинээр ЭБАТ-ын эрх авсан 2 албан тушаалтан /Дотоод аудит, Боловсролын хэлтэс/-нд мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллийг тухай бүр өгч ажиллав. Мөн шинээр ХАСУМ болон ХАСХОМ бөглөж байгаа 7 албан тушаалтанд холбогдох арга зүйн зөвлөгөөг өгөн ажилласан болно.	
	2.2 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн дотоод нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнах	Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан авлигын мэдээлэл хүлээн авах 2 төрлийг постерийг бэлтгэн дүүргийн веб сайтад байршуулж, Авлигын эсрэг хуулийг сурталчлах 2 төрлийн гарын авлага бэлтгэн 30 гаруй иргэдэд хүргэн ажиллав. Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг шүгэл үлээхэд уриалах, соён гэгээрүүлэх зорилгоор сурталчилгааны материал байршуулах боломжтой 3 самбарын судалгааг гарган Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс хүргэн ажиллав. Судалгаагаар УБ-Замын үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын дагуу 45м2, 8.7м2 хэмжээтэй 2 самбар, 2 дугаар хорооны байрны хойд хэсэгт 12м2 хэмжээтэй 1 самбар байна. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай хамтран УБ-Замын үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын дагуу 45м2 самбарт Авлигыг мэдээлэх пост байршуулахаар төлөвлөгдсөн.	70
3 Авлигатай тэмцэх газраас эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх хариуг хугацаанд нь	3.1 “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүн тооцож, тайлагнах	Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан дүүрэгт “Шүүр”, “Шил”, “Шүгэл” ажиллагааг амжилттай зохион байгуулж байна. “Шүүр” ажиллагааны хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны А/63 дугаар захирамжаар 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан дүүргийн Төрийн болон Орон нутгийн	100

мэдэгдэх		өмчит нийт 24 байгууллагын хамруулан хяналт шалгалт зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд тусгай шалгалт өгч томилогдоогүй 1 удирдах, 2 гүйцэтгэх албан тушаалтныг ажлаас чөлөөлсөн байна. “Шил” ажиллагааны хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаа. Үүнд: Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, 2008 оноос хойших газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан шийдвэрийн талаарх мэдээллийг бэлтгэн дүүргийн веб сайтад байршуулан олон нийтийг мэдээллээр ханган ажиллаа. “Шүгэл ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх “Авлигын эсрэг нэгдье” аянд гэгдэн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав.	
	3.2 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, саналыг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах	Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил болгон зарлаж “Шүүр” ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газраас 2022 онд хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулаагүй томилогдсон 9 албан тушаалтны жагсаалтыг ирүүлсэн. Тус ажлын хүрээнд жагсаалтад заагдсан 7 албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулан томилогооны зөрчлийг арилгаад байна. 2 албан хаагч нь Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтний ангилал зэрэглэл ТЗ-8 болон батлагдсан тул хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэггүй байна. “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай МУ-ын ерөнхий сайдын 01 дугаар албан даалгаврын хүрээнд дүүрэгт хамраалтай 5 арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг тусгай зөвшөөрөлтэй	100

		байгууллагын дэлгэрэнгүй судалгаа, тамхи худалдан борлуулдаг ААНБ болон иргэний судалгааг шинэчлэн badakhangaib.gov.mn цахим хуудсанд байршуулаад байна. Мөн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд badakhangaib.gov.mn цахим хуудсанд авлигын цонхонд тусгай болон энгийн зөвшөөрлийн жагсаалт, төрийн үйлчилгээний цонхонд шаардагдах бүрдүүлэх материалын зөвшөөрөл авахад шаардагдах бүрдүүлэх материалын жагсаалт байрлуулах цонх нээн ажиллаж байна.	
Байгууллагын удирдлагын тэмцэх авлигатай хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1 Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд хамрагдах	2023-2024 оныг Монгол Улсын засгийн газраас Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар дүүргийн хэмжээнд 2023 оныг “Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарлаж, зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 3 дугаар улирлын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 86.6% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдээд байна. Зорилтот жилийн биелэлтийг дүүргийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар 3 дугаар улирлын хэрэгжилт, анхаарах асуудлыг хэлэлцүүлээ. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аян зарлагдаагүй болно.	70
	4.2 Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгуулах	Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээнд авлигаас ангид байх авлигыг мэдээлэх гэсэн 2 заалтыг тусгуулан ажиллаж байна. Үүнд: Гэрээний нэмэлт нөхцөлд: 1.Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй 2.Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай	100

4

		тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. гэсэн 2 заалтыг тусгуулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 11 иргэний гэрээнд тусгасан байна. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй 5 "Ш" ажиллагааны хүрээнд дүүрэгт зохион байгуулагдаж байгаа "Шүүр", "Шил", "Шүгэл" ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар сэтгэл ханамжийн судалгааг бэлтгэн иргэдээс авсан болно. Судалгаагаар: "Шүүр" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 50%, "Шил" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 40.9%, "Шүгэл" ажиллагааны хэрэгжилт, үр дүн сайн гэж 59% нь үнэлсэн байна. Мөн Та https://bagakhangai.ub.gov.mn/ сайтын Авлига цонхонд байршуулсан "Таван Ш" ажиллагааны хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан мэдээлэлтэй танилцаж байсан уу гэсэн асуултад Тийм гэж 27.2%, Үгүй гэж 72.8% хариулсан байна. Авлигатай тэмцэх газрын захиалгаар "Шударга байдлын үнэлгээ -2023" судалгааны ажлыг "Эс Ай Си Эй" ХХК-тай хамтран 3 бүлгийн хүрээнд зохион байгууллаа. Багц-1: Иргэд үйлчлүүлэгчээс авах судалгаа -150 иргэн Багц-2: Төрийн албан хаагчаас авах судалгаа -15 албан хаагч Багц-3: Бодлогод оролцогч шинжээчдийн судалгаа -20 шинжээч нийт 185 иргэд албан хаагчдыг хамруулсан байна. Судалгааг түүврийн аргаар сонгож судлаач өөрөө асууж бөглөх зарчмаар авсан болно.	100
4.3	Үйлчлүүлэгчээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт: "Иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хурдан шуурхай, хүндрэл чирэгдэлгүй, хамгийн ойр цэгээс хүргэх" гэж заасны дагуу хороодын цогцолбор байранд төрийн цахим үйлчилгээний "Хурдан" цэгийг байгуулан, 12,0 сая төгрөгийн өртөг бүхий техник тоног төхөөрөмжөөр тохижуулав. 2-р хорооны "Хурдан" цэг нь 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд нийт 24 төрлийн лавлагаа, мэдээллийг 325 иргэнд үзүүлээ.	100
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх	
6	Байгууллагын үйл	6.1 Авлигын эсрэг хуулийн 6 дугаар	100

ажиллагааны ил тод байдлыг сайжруулах	зүйлийн 6.1.4 дахь заалт, 6.2 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дахь хэсэг, 6.3 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийт үзэж танилцах боломжоор хангах	хугацаанд шилэн дансанд санхүүгийн чиглэлээр 18 төрлийн 67 мэдээлэл, 207 захирамж, ЗДТГ-ын даргын 67 тушаал, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл 3-ыг байршуулаад байна. Мөн дүүргийн веб сайтын Ил тод үндсэн зэсэд Авлигын эсрэг үйл ажиллагааны дэд зэс нээлгэн Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, Шүүр ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийн захирамж, хэрэгжилтийн тайлан, "Шил" ажиллагааны хүрээнд МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайлан, Эрх зүйн хөтөч, Хүний эрхийн төлөв байдлын тайлан, Соёлын ордон, БТСХ-ны үйлчилгээний үнийн хэм хэмжээний актыг байршуулан ажиллаа.
	ҮНЭЛГЭЭ	95.3

Нийт 13 заалтыг хяналтанд авснаас 100 хувийн хэрэгжилттэй -11, 90 хувийн хэрэгжилттэй-0, 70 хувийн хэрэгжилттэй -2, 50 хувийн хэрэгжилттэй -0, 30 хувийн хэрэгжилттэй -0, тасарлсан -0 дундаж үнэлгээ 95.3%-тай байна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА



БОТГОНЖАРГАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХӨРӨНГӨ

ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН *H. Batcengal* Н.БАТЦЭНГЭЛ